



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ТАЙЛАН

*Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/26/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
odgerell@audit.gov.mn

Аудитор: Ж.Болормаа
Утас: 261628
Цахим хаяг:
bolormaaj@audit.gov.mn

Үндэсний аудитын газар

Засгийн газрын IV байр
Бага тойруу-3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

АГУУЛГА

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй,
хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон
нарийвчилсан горим, түүний үр дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх
тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол)
тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх
тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-САГ/2015/35/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 3-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 20-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын аудитор Ж.Болормаа гүйцэтгэж /ТАБ-СТА-А-9/, аудитын тайланг хуулийн хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төсвийн захирагч нь “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын санхүүжилт нийгмийн баталгааны тухай”, “Төсвийн тухай” зэрэг хуулиуд болон “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, “Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах журам”, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”, “Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай” зэрэг Засгийн газрын тогтоолын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны эрхэм зорилго нь хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн иргэн бүрийг өрсөлдөх чадвар бүхий "Зөв монгол хүн" болгон төлөвшүүлэх боловсролын олон талт нөхцөл, боломжийг бүрдүүлэх, үндэсний болон дэлхийн өв, соёлд суурилсан, үндэсний онцлог бүхий соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх, шинжлэх ухаан, инноваци, өндөр технологийн үр өгөөжийг сайжруулж эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д "Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн" ерөнхийлөн захирагч байна гэж заажээ.

Тайлант онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэсэн ба 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгосон байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

БСШУЯ-ны 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 2% буюу 23,951.8 сая төгрөгөөр тогтоов.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 21-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажилласан байна.

Тус яамны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн "Acolous" програмаар боловсруулж, санхүүгийн нэгтгэсэн тайланг "Plastic" програмаар гаргасан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

БСШУСайдын төсвийн багцад 2014 онд улсын төсвийн татаас санхүүжилтийн орлогоор 1,307,416.1 сая төгрөг батлагдсанаас 1,204,013.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 103,402.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУЯ-ны Сайдын 2015 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн А/01 дүгээр тушаал гарч мэдээлэл гаргах албан тушаалтан, мэдээллийн агуулга, хугацааны жагсаалтыг хавсралтаар баталсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 49 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- Дотоод хяналт сулрах, ажлын хариуцлага алдагдах,
- Холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байх,
- Зориулалтын бус зардал санхүүжүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах
- Яамны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сулрах, холбогдох журмын заалт зөрчигдөх

Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн

гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа үйлчилгээний орлого зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад нэгтгэгдсэн Боловсролын хүрээлэн, Насан туршийн боловсролын үндэсний төв, Монгол-Германы хамтарсан технологийн дээд сургууль зэрэг байгууллагын 2014 оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийсэн бөгөөд илэрсэн алдаа, зөрчил болон санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. БСШУСайдын эрхлэх асуудлын хүрээний 103 байгууллагаас 75% буюу 79 байгууллагын санхүүгийн тайлан аудитаар орсон байна. Үүнээс зөрчилгүй 67, хязгаарлалттай 3, сөрөг 1, дүгнэлт өгөхөөс татгалзсан 1, түүвэрт орсон 5, итгэл үзүүлсэн 2 байгууллага байна. Алдаа зөрчлийн нийт дүн 15,160.4 сая төгрөг байна. 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар Баян-Өлгий болон Өвөрхангай аймгийн Боловсрол, соёлын газар, Үлэг гүрвэлийн төв музей “хязгаарлалттай” санал дүгнэлт, Ховдын их сургууль “сөрөг” дүгнэлт авсан бол Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтын дагуу төсвийн шууд захирагчдыг аудитад бүрэн хамруулах, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-т заасны дагуу аймаг, нийслэлийн аудитын газраас хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

2. Нийт 44.5 сая төгрөгийн төлбөрийн акт тавигдсанаас 18.9 сая төгрөг нь цалин хөлс, шагнал урамшуулалтай холбоотой, 14.2 сая төгрөг нь зориулалтын бус зарцуулалттай холбоотой, 11.4 сая төгрөг нь анхан шатны баримтгүй, хууль эрх зүйн үндэслэлгүй гарсан зардалтай холбоотой тавигдсан акт байна.

Нийт 14,186.4 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөнөөс 13.7 тэрбум төгрөг нь Сургалтын төрийн сангийн өндөр хөгжилтэй оронд суралцагчдын зээлийн хүүгийн авлагын талаар арга хэмжээ авах тухай албан шаардлага байна. Мөн БСШУЯ-ны аппаратын тайланд тусгагдсан 350.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж нь холбогдох журмын заалтыг зөрчсөн, ШУТС-гийн 2002-2010 онд олгосон нийт 445.4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, эргэн төлүүлэх арга хэмжээ авах болон зээлийн барьцаанд тавьсан хөрөнгийг тулган шалгах албан шаардлага өгсөн байна.

Шийдвэрлэсэн: Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3. Насан туршийн боловсролын үндэсний төв, Боловсролын хүрээлэн, Монгол-Германы хамтарсан технологийн дээд сургуулийн 2014 оны санхүүгийн тайлан түүврээр аудит орсон бөгөөд материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд ҮАГ-т хүргүүлээгүйгээс аудитад хамрагдаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 8.9.1 “төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж,..” гэсэн заалтын дагуу санхүүгийн тайлангаа УАГ-т хүргүүлж байх зөвлөмжийг асуудлын бүртгэлд тэмдэглэв.

4. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 1,307,416.1 сая төгрөг батлагдсанаас 1,204,013.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч зардлын бүлгийн дүнгээр хэтэрсэн зардал гараагүй боловч зардлын ангиллаар урсгал зардал 375.7 сая төгрөг, гадаад томилолт 24.7 сая төгрөг, төвлөрсөн арга хэмжээ 10.3 сая төгрөг, хандив тусламж буюу оюутны тэтгэлэг 3,560.1 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтэрсэн үзүүлэлттэй гарсан байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах зөвлөмжийг асуудлын бүртгэлд тэмдэглэж танилцуулав.

5. Боловсролын төвлөрсөн арга хэмжээнд 57,835.4 сая төгрөг төсөвлөгдсөнөөс 53,697.1 сая төгрөг зарцуулагдсан байна.

Аудитын явцад тухайн дансны гүйлгээнээс түүвэрлэн анхан шатны баримт руу хөөн шалгахад “Сурах бичгийн ажлын хөлс” гэсэн гүйлгээний утгаар 78.4 сая төгрөгийн зардал гарсан нь БСШУСайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/489 дугаар тушаалаар бүтцийн өөрчлөлт болон өндөр насны тэтгэвэрт гарсан 6 хүнд олгосон буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардал байна.

Мэдээлэл сурталчилгааны зардалд нийт 310.5 сая төгрөг зарцуулснаас түүвэрлэн үзэхэд “Миний монголын бахархал” ТББ-тай хийсэн гэрээний төлбөр 20.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээний гүйцэтгэлийг гаргаагүй байна.

Италийн нийслэл Ром хотод зохион байгуулагдсан дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалтад боловсролын салбараас нийт 16 хүн оролцсоноос БСШУЯ-наас 6 хүн нийт 61.3 сая төгрөгийн зардал гаргаж оролцсон байна. Үүний 51.2 сая төгрөгийг төвлөрсөн арга хэмжээ данснаас Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын дансаар дамжуулан төлсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 4.1.17 “арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг” хэлнэ гэж заасан тодорхойлолттой нийцсэн арга хэмжээг санхүүжүүлэх зөвлөмж өгсөн ба дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалтад төсвийн хөрөнгөөр оролцсон хүмүүст төлбөрийн акт тавих төсөл боловсруулав.

6. Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй Сайдын тушаалуудын найдвартай байдал хангагдаагүй, 2014 оны Сайдын тушаал одоог болтол архивт шилжээгүй, тушаалын хадгалалт, хамгаалалт хангалтгүй, эмх замбараагүй байдалтай байна. Тухайлбал: Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай БСШУСайдын 2010-2014 оны нийт 27 /хавсралттай/ тушаалыг түүвэрлэн БСШУЯ-ны архив дах тушаалын эх хувьтай тулган үзэхэд 3 тушаал зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн: Дотоод хяналтыг сайжруулж, Сайдын тушаалын биелэлтийг эргэж хянах, тушаалын хавсралтын хуудас бүрийг баталгаажуулах, нэмэлт өөрчлөлт орсон хувилбарыг хавсаргаж архивт шилжүүлэх, БСШУЯ-ны ТНБД-ын 2015 оны 2 дугаар

сарын 12-ны өдрийн А/25 дугаар тушаалаар батлагдсан “Албан хэрэг хөтлөх журам”-ын 6.2.1 “Яамны жилийн үйл ажиллагаанаас бий болсон баримт бичгийг ... албан хаагчдаас дараа оны I улиралд багтаан авч архивын нэгж болгох” гэсэн заалтыг биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

7. БСШУЯ-ны аппаратын ерөнхий нягтлан бодогч тус яамны төсвийн ерөнхий нягтлан бодогч нар төрсөн эгч дүүс байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6.5. “Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: БСШУЯ-ны аппаратын санхүүгийн тайлангийн аудитаар холбогдох байгууллагаас дүгнэлт гаргуулах зөвлөмж өгсөн байна.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай БСШУСайдын 2010-2014 оны нийт 27 /хавсралттай/ тушаалыг түүвэрлэн БСШУЯ-ны архив дах эх тушаалтай тулган үзэхэд 2012 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/57 дугаар тушаалд овог нэр зөрсөн, 2012 оны 7 дугаар сарын 4-ны А/380 дугаар тушаалд Дэмбэрэл овогтой Анхзаяагийн нэр нэмэгдсэн, 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/181 дугаар тушаалд Жамбалдорж овогтой Алтантуяагийн нэр нэмэгдсэн зөрүү гарсан байна. Үүнээс, одоогийн байдлаар Д.Анхзаяа 32,000 ам.долларын зээл авсан, Ж.Алтантуяа зээл авсан оюутны жагсаалтад байхгүй байна. Иймд энэ асуудлыг эрсдэлийн болон гүйцэтгэлийн аудитаар дахин нягтлан шалгах шаардлагатай гэж үзлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 15,310.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 44.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 14,186.4 сая төгрөгийн албан шаардлага тавигдсан байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

Зөвлөмж

2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий Аудитор санал болгож байна.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Менежментийн захидал

Асуудал 1

Харьяа байгууллагуудын аудитын тайлангийн
дүгнэлтийн талаар

Асуудал 2

Санхүүгийн тайлангийн аудитаар тавигдсан акт,
албан шаардлагын талаар

Асуудал 3

Төвлөрсөн арга хэмжээ дансны талаар

Асуудал 4

Яамны үйл ажиллагааны дотоод хяналтын талаар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн ерөнхийлөн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АСУУДАЛ 1: Харьяа байгууллагуудын аудитын тайлангийн дүгнэлтийн талаар

Ажиглалт

БСШУСайдын эрхлэх асуудлын хүрээний 103 байгууллагаас 75% буюу 79 байгууллагын санхүүгийн тайлан аудитаар орсон байна. Үүнээс, зөрчилгүй 67, хязгаарлалттай 3, сөрөг 1, дүгнэлт өгөхөөс татгалзсан 1, түүвэрт орсон 5, итгэл үзүүлсэн 2 байгууллага байна. Алдаа зөрчлийн нийт дүн 15,160.4 сая төгрөг байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтын дагуу төсвийн шууд захирагчдыг аудитад бүрэн хамруулах, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-т заасны дагуу аймаг, нийслэлийн аудитын газраас хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлж ажиллах

Эрсдэл

Дотоод хяналт сулрах, ажлын хариуцлага алдагдах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 2: Санхүүгийн тайлангийн аудитаар тавигдсан акт, албан шаардлагын талаар

Ажиглалт

Нийт 44.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 14,186.4 сая төгрөгийн албан шаардлага тавигдснаас 18.9 сая төгрөгийн акт нь цалин хөлс, шагнал урамшуулалтай холбоотой зөрчилд, 13.7 тэрбум төгрөгийн албан шаардлага нь Сургалтын төрийн сангийн өндөр хөгжилтэй оронд суралцагчдын зээлийн хүүгийн авлагын талаар арга хэмжээ авах тухай, мөн БСШУЯ-ны аппаратын тайланд тусгагдсан нэг удаагийн тэтгэмжид зарцуулсан 350.0 сая төгрөгийн албан шаардлага байна.

Зөвлөмж

Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлж ажиллах

Эрсдэл

Холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 3: Төвлөрсөн арга хэмжээ дансны талаар

Ажиглалт

Төвлөрсөн арга хэмжээ данснаас “Сурах бичгийн ажлын хөлс” гэсэн гүйлгээний утгаар 78.4 сая төгрөгийн зардал гарсан нь бүтцийн өөрчлөлт болон өндөр насны тэтгэвэрт гарсан 6 хүнд олгосон буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардал, “Миний монголын бахархал” ТББ-тай хийсэн гэрээний төлбөр 20.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээний гүйцэтгэл гараагүй, Италийн нийслэл Ром хотод зохион байгуулагдсан дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалтад оролцсон хүмүүсийн төлбөр 51.2 сая төгрөгийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дансаар дамжуулан төлсөн зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 4.1.17 “арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг” хэлнэ гэж заасан тодорхойлолттой нийцсэн арга хэмжээг санхүүжүүлэх

Эрсдэл

Зориулалтын бус зардал санхүүжүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 4: Яамны үйл ажиллагааны дотоод хяналтын талаар

Ажиглалт

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй Сайдын тушаалуудын найдвартай байдал хангагдаагүй, 2014 оны Сайдын тушаал одоог болтол архивт шилжээгүй, тушаалын хадгалалт, хамгаалалт хангалтгүй, эмх замбараагүй байдалтай байна.

Тухайлбал: Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай БСШУСайдын 2010-2014 оны нийт 27 /хавсралттай/ тушаалыг түүвэрлэн БСШУЯ-ны архив дах тушаалын эх хувьтай тулган үзэхэд 3 тушаал зөрүүтэй байна.

Зөвлөмж

Дотоод хяналтыг сайжруулж, Сайдын тушаалын биелэлтийг эргэж хянах, тушаалын хавсралтын хуудас бүрийг баталгаажуулах, нэмэлт өөрчлөлт орсон хувилбарыг хавсаргаж архивт шилжүүлэх, БСШУЯ-ны ТНБД-ын 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/25 дугаар тушаалаар батлагдсан “Албан хэрэг хөтлөх журам”-ын 6.2.1 “Яамны жилийн үйл ажиллагаанаас бий болсон баримт бичгийг ... албан хаагчдаас дараа оны 1-р улиралд багтаан авч архивын нэгж болгох” гэсэн заалтыг биелүүлж ажиллах

Эрсдэл

Яамны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сулрах, холбогдох журмын заалт зөрчигдөх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2015.04.24 № 491

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
НИЙТ ДҮН	0.00	0.00
НИЙТ ХӨРӨНГӨ	0.00	0.00
МӨНГӨН ХӨРӨНГӨ	81,307,444,559.28	96,402,478,269.13
Кассанд байгаа бэлэн мөнгө	89,919,400.93	62,925,971.71
Төгрөг\ ЖМС	89,919,400.93	62,186,506.51
Гадаад валют	0.00	739,465.20
Банкинд байгаа бэлэн мөнгө	77,551,683,315.09	93,028,289,518.28
Төгрөг	77,551,683,315.09	93,028,289,518.28
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	74,146,896,814.93	92,230,346,566.02
Нэмэлт санхүүжилтийн харилцах	3,404,786,500.16	797,942,952.26
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.00	500,000.00
Хадгаламж	3,665,841,843.26	3,310,762,779.14
АВЛАГА	99,771,655,409.68	117,917,692,353.53
Ажиллагчидтай холбогдсон авлага	59,605,170.33	64,909,600.21
Төлбөртэй үйлчилгээний авлага	8,156,238,789.05	8,126,606,342.45
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	1,508,511,707.50	3,589,498,139.24
Бусад авлага	6,791,918,948.23	8,947,746,664.11
Байгууллагаас авах авлага	2,601,405,251.19	6,738,063,835.90
Гэрэл цахилгааны авлага	133,322.00	133,322.00
Түлш халаалтын авлага	0.00	1,461,700.00
Дотоод албан томилолтын авлага	1,920,000.00	0.00
Урсгал засварын авлага	0.00	128,800,000.00
Бусад зардлын тооцооны авлага	2,599,351,929.19	6,607,668,813.90
Хувь хүмүүсээс авах авлага	4,190,513,697.04	2,209,682,828.21
Зээлийн авлага	83,255,380,794.57	97,188,931,607.52
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	83,255,380,794.57	97,188,931,607.52
Хувь хүмүүст олгосон зээл	83,255,380,794.57	97,188,931,607.52
Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	83,255,380,794.57	97,188,931,607.52
УРЬДЧИЛГАА	1,355,920,651.66	1,053,065,279.11
Бусад урьдчилгаа	1,355,920,651.66	1,053,065,279.11
Урьдчилгаа тооцоо	32,345,040.00	360,006,109.66
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	14,206,460.00	223,950,888.66
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	2,125,000.00	110,327,785.00
Цалингийн урьдчилгаа	3,350,000.00	11,425,173.00
Томилолтын урьдчилгаа	12,663,580.00	14,302,263.00
Урьдчилж гарсан зардал	1,323,575,611.66	693,059,169.45
Урьдчилж төлсөн зардал	1,323,575,611.66	693,059,169.45
БАРАА МАТЕРИАЛ	11,053,513,107.55	15,221,582,233.90
Түүхий эд материал	2,150,900,241.17	2,835,530,208.32
Тусгай зориулалттай материал	1,814,955,063.90	2,482,992,187.21
Эм боох материал	37,098,504.84	24,975,636.42
Дуусаагүй үйлдвэрлэл	138,921,847.64	49,350,366.00
Бэлэн бүтээгдэхүүн	159,924,824.79	278,212,018.69
Хангамжийн материал	8,208,454,378.90	11,425,406,537.01
Бичиг хэргийн материал	478,190,104.93	588,819,001.31
Аж ахуйн материал	4,765,786,442.20	5,640,861,810.81
Сэлбэг хэрэгсэл	222,438,598.36	252,900,037.95

Түлш, шатах тослох материал	25,503,509.54	34,784,930.03
Барилгын засварын материал	322,654,751.45	260,298,976.80
Хүнсний материал	248,021,421.80	230,986,837.69
Малын тэжээл	2,611,500.00	2,011,500.00
Баглаа боодол	164,478,060.45	39,436,347.56
Бусад бараа материал	1,978,769,990.17	4,375,307,094.86
Мал амьтад	235,450,736.24	220,981,739.14
Бусад	458,707,751.24	739,663,749.43
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	193,488,533,728.17	230,594,818,135.67
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	215,476,358,360.17	317,576,743,594.79
Биет хөрөнгө	214,529,431,179.77	313,926,272,793.87
Барилга, байгууламж, орон сууц	150,590,760,932.26	189,411,017,632.96
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	288,707,604,955.38	341,879,566,150.24
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(138,116,844,023.12)	(152,468,548,517.28)
Авто-тээврийн хэрэгсэл	4,259,244,605.65	5,056,658,727.87
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	7,393,153,074.50	9,057,921,557.03
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(3,133,908,468.85)	(4,001,262,829.16)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	32,273,692,249.00	44,688,777,229.59
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	74,109,156,053.98	94,364,075,128.92
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(41,835,463,804.98)	(49,675,297,899.33)
Тавилга, аж ахуйн эд хогшил	12,924,570,215.34	16,186,325,392.34
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	25,920,377,353.70	31,457,629,854.82
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(12,995,807,138.36)	(15,271,304,462.48)
Зам, гүүрийн байгууламж	620,246,520.37	825,412,013.10
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	1,014,247,506.52	1,242,416,326.48
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(394,000,986.15)	(417,004,313.38)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,302,304,169.81	29,650,925,173.07
Бусад үндсэн хөрөнгө	7,307,107,935.34	13,463,590,643.44
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	9,550,631,635.98	16,715,334,860.40
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(2,243,523,700.64)	(3,251,744,216.96)
Дуусаагүй барилга, байгууламж	5,251,504,552.00	14,643,565,981.50
Биет бус хөрөнгө	946,927,180.40	3,650,470,800.92
Програм хангамж	563,692,227.35	2,211,200,565.07
Програм хангамж - Анхны өртөг	1,129,535,306.00	2,881,361,077.50
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(565,843,078.65)	(670,160,512.43)
Бусад биет бус хөрөнгө	383,234,953.05	1,439,270,235.85
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	410,728,518.33	1,493,795,941.20
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(27,493,565.28)	(54,525,705.35)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	408,964,892,088.34	548,171,561,730.46
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,478,508,059.49	27,595,718,476.42
Өглөг	2,962,811,817.29	6,362,839,792.80
Ажилчидтай холбогдсон тооцоо	239,607,083.23	242,223,144.21
Цалингийн өглөг	127,122,611.72	119,467,689.09
НДШ-ийн өглөг	36,836,679.45	31,480,175.91
ХАОАТ-ын өглөг	31,271,617.43	45,995,481.19
ҮЭ-ийн өглөг	44,376,174.63	45,279,798.02
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	808,215,825.23	1,652,705,484.73
Гэрэл цахилгааны тооцоо	903,192.00	0.00
Түлш халаалтын тооцоо	683,807.00	43,470,663.00
Шуудан холбооны тооцоо	524,795.00	176,829.80
Цэвэр, бохир усны тооцоо	26,000.00	290,950.00
Тээвэр шатахууны тооцоо	1,620,000.00	1,218,806.00
Байрны түрээсийн тооцоо	1,199,931.18	2,328,115.00

Байрны засварын тооцоо	0.00	1,357,160.00
Бусад зардлын тооцоо	803,258,100.05	1,603,862,960.93
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо	140,221,245.36	92,992,121.80
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	26,533,194.00	490,097,724.00
Зээлийн хүүгийн тооцоо	14,220,000.00	0.00
Бусад өглөг	1,734,014,469.47	3,884,821,318.06
Байгууллагад төлөх өглөг	1,600,625,597.29	3,493,445,291.24
Хувь хүмүүст төлөх өглөг	133,388,872.18	391,376,026.82
Урьдчилж орсон орлого	17,515,696,242.20	21,232,878,683.62
Төсөвт байгууллага	17,370,692,236.33	21,087,732,152.02
Урьдчилж орсон орлого	17,370,607,356.33	21,087,732,152.02
Урьдчилж орсон хөрөнгийн орлого	84,880.00	0.00
Бусад урьдчилж орсон орлого	145,004,005.87	145,146,531.60
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	131,026,007.48	205,007,278.88
Урт хугацаат зээл	131,026,007.48	205,007,278.88
Гадаад валют	131,026,007.48	205,007,278.88
Олон улсын санхүүгийн байгууллагаас	131,026,007.48	205,007,278.88
Санхүүгийн зээл	36,936,308.10	0.00
Төслийн зээл	94,089,699.38	205,007,278.88
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	20,609,534,066.97	27,800,725,755.30
Засгийн газрын хувь оролцоо	388,355,358,021.37	520,370,835,975.16
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	145,834,138,789.08	172,341,345,883.02
Хуримтлагдсан үр дүн	140,496,279,608.83	222,858,250,258.66
Өмнөх үеийн үр дүн	140,496,279,608.83	140,574,024,340.59
Тайлант үеийн үр дүн	0.00	82,284,225,918.07
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,024,939,623.46	125,171,239,833.48
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	388,355,358,021.37	520,370,835,975.16
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	408,964,892,088.34	548,171,561,730.46

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
НИЙТ ДҮН	0.00	0.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	921,347,518,900.71	301,204,883,128.81
Гадаад орнуудаас үзүүлсэн	1,146,343,304.11	14,405,427,615.95
Урсгал	1,146,343,304.11	14,405,427,615.95
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	920,201,175,596.60	286,799,455,512.86
Улсын төвлөрсөн төсвөөс	919,611,104,994.60	284,586,621,004.53
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	866,469,541,483.24	244,831,608,661.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	0.00	28,600,000.00
Хөрөнгийн	13,844,235,769.00	23,405,158,666.30
Санхүүгийн зээлээс санхүүжих	6,622,778,100.00	0.00
Тусламжийн сангаас санхүүжих	12,378,675,248.09	0.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	20,295,874,394.27	16,321,253,677.23
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	49,068,155.11	3,129,860,865.90
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгуулл	633,145,705.54	621,910,122.78
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	666,598,275.00	1,807,126,289.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	14,855,260,363.81	8,772,287,772.21
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,091,801,894.81	1,094,736,327.34
Төсвийн урамшуулал	0.00	895,332,300.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	207,852,300.00	1,521,243,797.02
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,852,300.00	1,521,243,797.02
Төсөвт байгууллагаас	0.00	413,898,536.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	397,253,590.00
Хөрөнгийн	0.00	16,644,946.00
Нийгмийн даатгалын сангаас	382,218,302.00	277,692,175.31
НДС-ийн шилжүүлэг	382,218,302.00	277,692,175.31
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,017,052,089.45	216,720,759,958.74
Өмчийн орлого	2,229,743,190.39	2,948,982,460.53
Хүүгийн орлого	2,003,999,852.93	2,614,324,452.53
Түрээсийн орлого	225,743,337.46	334,658,008.00
Төрийн өмч түрээслүүлсний орлого	225,743,337.46	334,658,008.00
Бараа, үйлчилгээний борлуулалт	144,628,363,618.06	213,591,953,041.37
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	144,628,363,618.06	213,591,953,041.37
Үндсэн үйл ажиллагааны орлого	120,705,507,069.53	143,979,708,886.73
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	15,882,169,034.03	19,914,911,036.64
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	87,469,208.40	0.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,953,218,306.10	49,697,333,118.00
Торгууль, шимтгэл	550,000.00	41,078,185.86
Татварын бус бусад орлого	158,395,281.00	138,746,270.98
Хөрөнгийн орлого	158,395,281.00	138,746,270.98
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,068,364,570,990.16	517,925,643,087.55
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	120,192,680,588.83	146,056,166,080.96
Үндсэн болон нэмэгдэл цалин	108,537,480,530.47	131,468,801,541.32
Үндсэн цалин	103,786,875,795.47	121,707,590,567.89
Гэрээт ажилчдын цалин	4,379,666,334.08	8,309,272,515.41

Унаа хоолны хөнгөлөлт	73,768,837.00	230,040,771.56
Бусад нэмэгдлүүд	297,169,563.92	1,221,897,686.46
Үр дүнгийн урамшуулал	50,047,441.92	298,388,111.00
Илүү цагийн нэмэгдэл	110,632,050.00	94,141,327.00
Унаа, болон бусад нөхөн олговор	134,604,651.00	829,368,248.46
Бусад нэмэгдэл	1,885,421.00	0.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	11,655,200,058.36	14,587,364,539.64
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	9,688,950,766.46	12,548,678,176.91
Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,601,702,172.90	10,448,250,391.63
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	748,027,022.61	797,080,309.84
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	917,221,402.83	1,030,328,148.57
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	196,468,866.07	271,784,802.87
Бүтцийн өөрчлөлтийн цалингийн НДШ	225,531,302.05	1,234,524.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,966,249,291.90	2,038,686,362.73
УРСГАЛ ЗАРДАЛ	221,526,247,983.38	129,261,020,609.81
Бараа үйлчилгээний урсгал зардал	82,951,940,547.79	100,761,412,071.88
Тогтмол зардал	9,955,701,554.46	12,425,165,618.28
